



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/667

Арвайхээр

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “б”, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2014 оны 298 дугаар тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг (2019-2022 он) хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж хэрэгжилтийн явц, үр дүнг хагас бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.
3. Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101257



Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дүгээр сарын 28-ны өдрийн захирамжийн хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2019-2022 он/

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хамтран ажиллах байгууллага	Хүрэх үр дүн	Хөрөнгийн Эх үүсвэр
Зорилт 1. Хог хаягдлын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, аймаг орон нутгийн хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох					
1.1	Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцож батлуулах	2019	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумдын Засаг дарга	Тариф батлагдсан байна.	-
1.2	Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг батлуулж мөрдөх	2019	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, холбогдох байгууллагууд	Журам батлагдаж, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	-
1.3	Сум бүр хог хаягдлын үйлчилгээний төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлж хууль тогтоомжийн дагуу зарцуулах	2019-2022	Сумын ЗДТГ, Татварын хэлтэс	Хог хаягдлын үйлчилгээний хураамжаас төвлөрсөн орлогыг хуульд заасны дагуу зарцуулсан байна.	-
1.4	Аялал жуулчлалын холбоотой хамтран аялал жуулчлалын бүс нутаг дахь хог хаягдлын менежментийг сайжруулах	2020	ОХБЦГХЗ, БОАЖГ, сумдын ЗДТГ, Аялал жуулчлалын холбоо	Аялал жуулчлалын салбарын хог хаягдлын менежмент сайжирна.	Хувийн хэвшил
1.5	Сум бүр хог хаягдлын төвлөрсөн цэгээ тохижуулж, хашаажуулах, байнгын харуул хамгаалалттай болгох ажлыг зохион байгуулах	2019-2022	Сумын ЗДТГ	Төвлөрсөн цэгийн хог хаягдал салхи, усаар тарах, хөрс бохирдохоос урьдчилан сэргийлсэн байна.	Орон нутгийн төсөв
1.6	Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл	2020-2022	БОАЖГ Сумын ЗДТГ	Шинэ санал санаачилга нэвтрүүлсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд дэмжлэг үзүүлж, урамшуулсан байна.	Орон нутгийн төсөв

	ажиллагааг дэмжиж урамшуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх				Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Арвайхээр сумын ЗДТГ	Орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байгуулагдаж, үйл ажиллагаа сайжирсан байна.	Улсын болон орон нутгийн төсөв
1.7	Хог хаягдлын менежмент хариуцсан Орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгжийг байгуулж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	2020					
Зорилт 2. Хог хаягдлыг хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүйгээр ангилан ялгах, дахин боловсруулах дэвшилтэд техник технологийг нэвтрүүлэх замаар хог хаягдлыг багасгах, байгаль орчны бохирдлыг бууруулах							
2.1	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгадаг тогтолцоог нэвтрүүлж, ангилан ялгах цэг байгуулах	2019-2022		Аймаг, сумын ЗДТГ	Эх үүсвэр дээр нь ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ нэмэгдсэн байна. /тн/жил/	Улсын болон орон нутгийн төсөв	
2.2	Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд, нийтийн эзэмшлийн гудамж талбайд хог хаягдлыг ангилан ялгах сав, санамж самбар зэргийг байрлуулах	2019-2020		Сумдын ЗДТГ, ТҮК	Хог хаягдал ангилан ялгах сав, санамж самбарын тоо нэмэгдсэн байна.	Орон нутгийн төсөв	
2.3	Төвлөрсөн хогийн цэгт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2020		БОАЖГ сумдын ЗДТГ, МХГ	Төвлөрсөн хогийн цэгт Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэж, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.	Орон нутгийн төсөв	
2.4	Улсын болон орон нутгийн чанартай авто замын дагуу хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, хог хаяхыг хориглосон тэмдэгжүүлэлт санамж, самбар, хогийн сав байрлуулах	2019-2020		ОХБЦГХЗ, МХГ, сумдын ЗДТГ, ӨВ-АЗЗА ТӨХК, Хархорин –АЗЗА ТӨХК	Улсын болон орон нутгийн чанартай авто зам, замын дагуу эзэнгүй хог хаягдлын хэмжээ буурсан байна.	Орон нутгийн төсөв	
2.5	Төвлөрсөн хогийн цэг дээр ажиллах машин механизм болон тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн парк шинэчлэлт хийж, хүрэлцээ хангамжийг сайжруулах	2019-2020		Аймаг, сумын ЗДТГ, төсөл, хөтөлбөр	Хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах тээврийн хэрэгслийн нэр төрөл, тоо нэмэгдсэн байна.	Орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөр	
2.6	Нийтийг хамарсан баяр ёслол, арга хэмжээний үеэр хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх	2019-2022		БОАЖГ, МХГ Сумдын ЗДТГ	Орчны бохирдол багассан байна.	Улс, орон нутгийн төсөв	

2.7	Бүх нийтийн цэвэрлэгээг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулж хэвших	2019-2022	БОАЖГ, сумдын ЗДТГ	Эзэнгүй хур хог хаягдлын эзлэх талбайн хэмжээ багасч, байгууллага аж ахуйн нэгжүүд ойролцоох 50м доторх хог хаягдлыг цэвэрлэж хэвшсэн байна.	
2.8	Шинээр баригдаж байгаа нийтийн орон сууц, үйлдвэр үйлчилгээний газруудын зураг төсөвт хог ангилан ялгаж хаях сав /цэг/-г тусгаж, хүлээн авч хэвших	2019-2020	МХГ, ГХБХБГ, сумдын ЗДТГ	Хог хаягдлыг зориулалтын бус газарт ил задгай хаяхгүй байх нөхцөл бүрдсэн байна.	Хувийн хэвшил
Зорилт 3. Аюултай хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох					
3.1	Аюултай хог хаягдлын судалгааг хийж мэдээллийн нэгдсэн сантай болох	2020	БОАЖГ, сумдын ЗДТГ	Аюултай хог хаягдлын нэгдсэн мэдээлэлтэй болно.	-
3.2	Монгол улсын Засгийн газрын 2015 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 264 дүгээр тогтоол /Аюултай хог хаягдлын жагсаалт/-ыг хүрээнд аюултай хог хаягдлыг түр хадгалах байгууламжтай болох.	2021-2022	Холбогдох байгууллагууд	Аюултай хог хаягдлын хадгалалт хамгаалалт сайжирч, байгаль орчинд ил задгай хаях байдал буурна.	Улс, орон нутгийн төсөв
Зорилт 4. Хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах, орчны бохирдлыг багасгах талаар иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх					
4.1	Иргэдийн дунд ахуйн хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын уут сав хэрэглэх, хогийн цэгт хаях дадал хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааны арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр зохион байгуулах	2019-2022	Холбогдох байгууллага, Сумдын ЗДТГ	Иргэдийн хог хаягдлыг байгаль орчин үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах зөв дадлыг төлөвшүүлсэн байна.	Орон нутгийн төсөв
4.2	Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, гадаад, дотоодын сургалтад хамруулж мэргэшүүлэх; туршлага судлуулах ажлыг шат дараатай зохион байгуулах	2020-2022	Аймаг, сумын ЗДТГ БОАЖГ	Хүний нөөцийн чадавх нэмэгдсэн байна.	Улс орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр
4.3	Химийн бодисын хор хөнөөлийн талаар иргэдэд таниулах ажлыг зохион байгуулах	2019-2022	Аймаг, сумын ЗДТГ БОАЖГ	Химийн бодисын ашиглалт, хадгалалт, хор хөнөөлийн талаар мэдлэг мэдээлэлтэй болсон байна.	Орон нутгийн төсөв